



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/157

Номгон

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн  
бүртгэл үзлэг, тооллогыг зохион байгуулах  
тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.10, “Автотээврийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйл 7.1.1, 7.1.3, “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Зам тээврийн хөгжлийн яамны сайд, Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/57/48 тоот хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймагт бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийг журмын дагуу үзлэг, тооллогод бүрэн хамруулах арга хэмжээг аймгийн хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Батсуурь - Аймгийн Засаг даргын орлогч
- Б.Мөнхбаяр – Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа
- С.Рэнцэндагва - Татварын хэлтсийн дарга
- Т.Хишигбаатар-Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- Ц.Идэрмөнх – Орон нутгийн өмчийн газрын дарга
- Сумдын Засаг дарга нар
- Нарийн бичгийн дарга: С.Амармөнх - Автотээврийн төвийн дарга

3.Арга хэмжээний үеэр авч хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4.Тооллогын арга хэмжээг зохион байгуулсан ажлын үр дүнг нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор танилцуулсныг комиссын дарга /Б.Батсуурь/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

842310403

Аймгийн Засаг даргын...-ны ...сарын...-ны  
өдрийн... дугаар... захиралын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 27

Номгон

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн  
бүртгэл үзлэг, тооллогыг зохион байгуулах  
тухай

**Нэг. Зорилго:**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6.2, 7 дугаар зүйлийн 7.1 “Автотээврийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дэх заалт, ЗТХЯамны сайд, Сангийн сайдын 2023 оны 03 сарын 03-ны өдрийн А/57/48 хамтарсан тушаалыг хэрэгжүүлэхэд оршино.

**Хоёр. Хугацаа**

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллого зохион байгуулах ажлыг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг дуустал

**Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага:**

- Автотээврийн төв

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд:

- Засаг даргын тамгын газар
- Татварын хэлтэс
- Цагдаагийн газар
- Орон нутгийн өмчийн газар
- Сумдын Засаг даргын тамгын газар
- Албан журмын даатгагчдын холбоо

### Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Ажлын алба	Хийх ажлын хуваарь	Хариуцах эзэн
1	2	3	4
1	Автотээврийн төв	<p>1.Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн ажлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг зохион байгуулах</p> <p>2.Тооллогод хамрагдах тээврийн хэрэгслийн судалгааг сум тус бүрээр гаргаж, тооллогыг зохион байгуулах ажлын хэсгүүдэд хүргүүлэх</p> <p>3.Сумдад байгуулагдсан тооллогын ажлын хэсгүүдийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж тооллогын ажилд хяналт тавьж ажиллах</p> <p>4.Тооллогод хамрагдсан автотээврийн хэрэгслийн мэдээллийг сумдаас авч нэгтгэж мэдээг өдөр дутам гаргах</p>	Автотээврийн төв С.Амармөнх
2	Татварын хэлтэс Сумдын ЗДТГ	<p>1.Сумын засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилж тооллогын ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах</p> <p>Үүнд: Сумын тооллогын комисст татварын улсын байцаагч, багийн Засаг дарга, багийн нийгмийн ажилтан, цагдаагийн байгууллагын алба хаагч зэрэг үүрэг бүхий бусад хүмүүсийг оролцуулна. -Тооллогыг зохион байгуулагдахаас өмнө тээврийн хэрэгслээ зарсан боловч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй, цаашид ашиглах боломжгүй болсон боловч албан ёсны хасалт хийлгээгүй, олон жилийн хуримтлагдсан татварын өртэй, торгуультай тээврийн хэрэгсэл эзэмшигчидтэй биечлэн болон утсаар холбогдож тухайн тээврийн хэрэгсэл дээрх өрийн мэдээлэлийг өгч, үүссэн өрийн барагдуулан ажиллана.</p> <p>2.Тооллогын ажлын хүрээнд нийт 6839 тээврийн хэрэгслийн эзэмшигч бүртэй холбогдож тооллогод хамрагдах жагсаалтанд орсон автомашин бүрийг хамруулсан байх</p> <p>3.Жагсаалтанд орсон тээврийн хэрэгслийг байршил дээр нь үзэж шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, хөдөлгүүрийн мэдээллийг холбогдох апплейкшинд заасан үзүүлэлт бүрээр баталгаажуулан авч сан үүсгэнэ</p> <p>4.Тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг, багийн засаг дарга нар нь харъяа нутаг дэвсгэртээ байгаа хасагдах тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэн гаргаж, бүртгэлээс хасуулах тээврийн хэрэгслийн эзэмшигч бүрээс хүсэлтийг хүлээн авч</p>	Татварын хэлтсийн дарга С.Рэнцэндагва Сумдын Засаг дарга нар

		тооллогын ажлын хэсэгт хүлээлгэн өгөх 5.Сумдын Засаг дарга нар тооллогын үйл явцад биечлэн хяналт тавьж дүнг нэгтгэн гаргаж Аймгийн комисст хүргүүлнэ.	
3	Цагдаагийн газар	1.Гэмт хэрэг зөрчлийн улмаас журамлагдсан, саатуулагдсан тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллогод хамруулахад анхаарч ажиллах 2.ЗГ-ын 2022 оны 47 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу тээврийн хэрэгслийн ТХҮзлэгт ороогүй, АТБӨЯХ-ийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй тохиолдолд автозамын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллах	Цагдаагийн Газрын дарга /Б.Мөнхбаяр/
4	Орон нутгийн өмчийн газар	1.Төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллогод бүрэн хамруулах 2.Төрийн болон орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр шилжилт хөдөлгөөн болон хасалт хийгдээгүйгээс болж татварын өр үүсэж тухайн өмлөгч дээрээ бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийн баримт бичгийг бүрдүүлж бүртгэлээс хасуулах, шилжүүлэх, үүссэн өр төлбөрийг барагдуулах	ОНӨГ-ын дарга Ц.Идэрмөнх

oOo